

**Хьюстон Спенсер, Монголын Уул Уурхайн Чуулга Уулзалт, Перт хот, 2013 он
2013 оны 10 дугаар сарын 31**

Эрхэм сайд аа, Монголын болон олон улсын зочид төлөөлөгчид өө, та бүхэнтэй энэ өдөр уулзаж байгаадаа баяртай байна.

Бусад компаниудын адилаар Рио Тинтод аюулгүй ажиллагаа амин чухал. Оюу Толгойд бид бүх ажлаа аюулгүй ажиллагааны зөвлөмжөөр эхэлдэг тул энэ илтгэлээ ч ялгаагүй эхэлье. Ингэснээр аюулгүй ажиллагаа нь бидний гэр бүлийн амьдрал болоод ажлын байранд хэрхэн ач холбогдолтой гэдгийг бие биедээ сануулах боломж олгодог.

Эдгээр тэмдгүүдийг манай уурхай дээр байгаа томоохон барилга бүр дээр байрлуулдаг. Оюу Толгой руу машинаар ирэх хүн бүр хамгийн түрүүнд бидний суурь үнэт зүйлс болох аюулгүй ажиллагааны тухай сануулгыг харч авах ёстой. Энэхүү аюулгүй ажиллагааны сануулга агшин зүүр өнгөрөх боловч бид бүгдийн хувьд ажлын өдрөө зөв сэтгэлээр эхлүүлэхэд тус дөхөм болдог юм.

Өнөөдрийн миний илтгэл “Төслийн тухай шинэ мэдээ” гэсэн гарчигтай. Гэхдээ та Монголын уул уурхайн талаар сонирхож байгаа бол, манай төслийн тухай хэдийнэ тодорхой мэдлэгтэй болсон байх.

Оюу Толгой бол Монгол улсын Засгийн газар, Рио Тинто болон Туркойз Хилл Ресурс компаниудын хоорондын түншлэл мөн.

Энэхүү зураг нь Ханбумбат нисэх буудалд газардаж, уурхайг зорин явах замд танд харагдах дүр зураг.

Энэ жил бид өдөрт 100 мянган тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулан нийт ордын багахан хэсгийг эзлэх ил уурхайгаас олборлосон хүдрээ боловсруулж эхэллээ.

Энэ сард л гэхэд БНХАУ-ын гаалийн байгууллагаас манай баяжмалыг хэрэглэгч нарт хүргэж өгөхийг зөвшөөрснөөр манай үйлдвэрлэлийн үйл ажиллагааны сүүлийн чухал ажил биеллээ оллоо. Энэ нь бид одоо олборлолтоос эхлэн борлуулалт хүртэл бизнесийн үйл ажиллагааныхаа жинхэнэ утгаар нь бүрэн явуулж байна гэсэн үг юм.

Оюу Толгой бол үүнээс урт удаан түүхтэй юм. ЗХУ-ын геологчид БНХАУ-ын

хилээс 80 км зайд орших өмнийн говийн нутгийг 70,80-аад онд судалж эхэлсэн. Оюу өнгөтэй хөрс, эрт үед зэс хайлуулж байсан түүх тэдний сонирхлыг энэ нутаг руу чиглүүлсэн гэдэг.

Үүнээс хойш дахин хэд хэдэн удаа оролдлого хийсний дараа, шинэ мянганы эхээр Айвенхоу Майнз гэдэг Канадын жижигхэн компани жинхэнэ ёсоор хайгуулын ажлаа эхлүүлсэн юм. Энэ хайгуулын ажил амжилт ололгүйгээр дуусах гэж байсан, гэхдээ 2001 оноос 2005 оны хооронд тэд хэд хэдэн гайхалтай нээлт хийж, Манхэттен арал шиг том хүдрийн биетийг нээн илрүүлжээ.

Энэ цэгт хүрэхэд бараг арван жил шаардагдлаа. Төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар хэлэлцээ хийх төдийгүй, энэ бүгд нь Монгол улсын хувьд ямар үр дагавартай байх талаар ойлголт бий болгохын тулд энэ арван жилийн зарцууллаа.

Рио Тинто компанийг төслийн удирдагчаар сонгон хөрөнгө оруулагчаар оролцуулснаар бүх холбогдох талуудын хувьд энэ төслийг жинхэнэ олон улсын түншлэл болгох шийдвэрийн илрэл болсон юм.

Та бүхэн Рио Тинтогийн сүүлийн улирлын мэдээг уншсан бол бид одоогийн байдлаар 160 гаруй мянган тонн баяжмал үйлдвэрлэсэн гэдгийг мэдэж байгаа байх. Оны эцсийн байдлаар бид 75-аас 85 мянган тонн зэс агуулсан баяжмал үйлдвэрлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2014 он гарахаас өмнө борлуулалтын төлөвлөгөөг үйлдвэрлэлийн хэмжээнд хүргэхээр ажиллаж байна.

Гэхдээ та бүхэнд энэ төслийг дан ганц статистик үзүүлэлтээс арай өөр өнцгөөс харуулмаар байна.

Оюу Толгой төсөл бол Монгол дахь хөрөнгө оруулалтын талаар ямар сургамж өгч байгааг ярья. Та бүхэнтэй хуваалцах миний санаа бол огт шинэ санаа биш ээ, гэхдээ энэ нь Оюу Толгой төслийн туршлагаас авах хамгийн чухал сургамж мөн.

Тэгээд Перт хот бол энэ санаа, энэ сургамжийг өгөх хамгийн зөв зохистой газар мөн гэж үзэж байна.

Перт хот бол дэлхийн уул уурхайгаа овоглосон нийслэл хотуудын нэг гэж хэлж болно, иймд манай салбарын хамгийн залуу уул уурхай бүхий нэгэн улстай харьцуулалт хийх нь сонин санагдаж магадгүй.

Баруун Австралид өнөөдөр бид Австралийн эдийн засгийн үндэс суурь болсон хүчирхэг уул уурхайн салбарыг харж байна - энэ бол нэг өдрийн дотор бий болсон зүйл биш. Энэ бол дөч гаруй жилийн туршид алсын хараа, итгэл үнэмшил, тэвчээр гарган хийсэн хөрөнгө оруулалтын үр дүн юм. Энэхүү өмнөх үеийн хөрөнгө оруулалт, тус салбарт урт хугацаанд тууштай анхаарлаа тавьж байж өнөөгийн эдийн өсөлт, ажлын байр, хөрөнгө оруулалтын жинхэнэ суурь үндсийг бий болгосон билээ. Эндээс замын цаана байрладаг манай ах дуу нар болох Рио Тинто Төмрийн Хүдрийн группийнхэн өнөөдөр дахиад л 50 гаруй жилийн турш ажиллах уурхайг төлөвлөж байгаа юм. Манай салбарт үнэхээр маш урт удаан хугацаагаар ажиллахаас өөр аргагүй.

Энэ бол Оюу Толгойн туршлагаас авах маш энгийн нэгэн сургамж мөн: Монголд хөрөнгө оруулалт хийх бол маш урт хугацааны итгэл үнэмшил шаардагдах болно.

Өчигдөр Оюу Толгой компанийн ТУЗ-ийн дарга Г.Батсүх Монголын түүх, өнөөгийн байдал ба ирээдүйн тухай та бүхэнд өгүүлсэн. Түүний гол санаа бол сонингийн мэдээний гарчигт үе үе Монголын тухай маш хурцаар бичигдэх болдог, дараа нь энэ нь аажмаар сулардаг, гэсэн хэдий ч Монгол улс үүнийг үл харгалзан урт хугацааны туршид байнга л ахиц дэвшилтэй, урагшаа явж байгаа тухай өгүүлсэн.

Мөрөөдөл бүхэн түргэн биелдэггүй. 20 дугаар зууны хамгийн сайхан мөрөөдөлтэй нэгэн хүн болох Мартин Лютер Кинг “Энэ хорвоод шударга ёс байдаг, түүнд хүрэх зам нь урт удаан боловч эцсийн эцэст заавал хүрэх болно” гэж хэлж байлаа.

Бизнес, хөрөнгө оруулалтын тухай ярьж байхдаа энэ хорвоогийн шударга ёсны тухай дурьдах нь хэтрүүлэг байж магадгүй. Гэхдээ олон арван жилийн турш биелэгдэх мөрөөдлийн тухай санаа бол харин зохимжтой санагдаж байна.

Бид Оюу Толгойн бүтээн байгуулалтыг гуравхан жилийн дотор дуусгасан гэж ярьдаг боловч Оюу Толгойд хайгуулын ажил бараг 20 жилийн өмнө эхэлсэн байдаг.

Оюу Толгойн бүтээн байгуулалт, олборлолт, үйлдвэрлэлийн эхлэл бол асар том сорилт байлаа: энэ нь саад тотгорыг давсан холч ухаан, хичээл зүтгэлийн түүх мөн.

Агаарын температур нь -40С-с +40С хүртэл хэлбэлздэг говь нутагт бидэнд хэрэгтэй ямар ч дэд бүтэц алга байсан. Гэсэн хэдий ч гуравхан жилийн дотор гайхамшигт итгэл үнэмшил гарган зургаа гаруй тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсний үр дүнд бид хөл дээрээ зогссон гэж хэлж болно.

Та нар Оюу Толгойд зочлох үед, таны анхны төсөөлөл, манай ажиллагсадын хийж бүтээсэн зүйл нь асар их зөрүүтэй байх болно.

Энэ нь Монголын аж үйлдвэрийн түүхэнд хамгийн том дэвшил авчрах баяжуулах үйлдвэр, аварга том экскаватор, ачааны машинаар ч хязгаарлагдахгүй.

Оюу Толгойн сургамж бол зохих хэмжээний итгэл үнэмшилтэй цагт та дэлхийн түвшний хамгийн орчин үеийн байгууламжийг дэд бүтэц огт хөгжөөгүй, хүнд хатуу орчинд ч байгуулж чадна гэдгийг харуулж байна.

Гэхдээ энэ бүх бетон, ган төмрийн цаана төсөл дээр ажиллаж буй 8,500 хүний эерэг энергийг мэдрэн биширхээс өөр аргагүй билээ.

Оюу Толгойд хамгийн хэцүү хүнд өдрүүдэд ч манай залуу, бахархалтай сайхан ажилчдыг хараад энэ бүх ажил нь үнэхээр үнэ цэнтэй байсан гэж надад бодогддог. Тэд бүгд Монголын хөгжлийн нэгэн сонирхолтой түүхийг өгүүлнэ.

- Оюу Толгойд цэвэрлэгчээр ажилд орсон боловч одоо 300 тонны Комацу ачааны машины жолоо мушгидаг эмэгтэй.
- Дэлхийн түвшний аудит, ил тод байдлыг хэрэгжүүлж буй залуу төгсөгч.
- Компанийн ажлыг шударгаар явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг, өвөг дээдсийн газар нутгаа хамгаалах итгэл үнэмшил, хүсэл тэмүүллээр дүүрэн нэгэн байгаль орчны ажилтан.

Эдгээр манай ажиллагсдын итгэл үнэмшил нь сайн компани заавал хүн дээр тогтдог гэдгийг сануулж байна.

Бид сүүлийн хэдэн долоо хоногт л орлогоо олж эхэлсэн боловч тэдний нөлөөлөл бол хэдийнэ мэдрэгдэхээр болсон байна.

Ийм хэмжээний ажлыг хийхдээ, ийм их хөрөнгө зарцуулахад тууштай, үнэнч зан, сахилга бат хэрэгтэй.

Энэ итгэл үнэмшил бас тийм ч амар анзаарагдахгүй өөр нэг хэлбэрээр ч илэрдэг.

Бэрхшээл сорилтыг даван туулах үед ч энэхүү итгэл үнэмшил нь бат бөх байдаг нь бид бүгд Монгол орны төлөө байнга л ярьж, бусдад хөрөнгө оруулалтаар бий болох хамтын ирээдүйг харуулахын төлөө ажиллаж байлаа.

Бид Монголын олон хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад тогтмол оролцдог бөгөөд миний хувьд хэд хэдэн уулзалтад компаниа төлөөлөн оролцох сайхан завшаан гарч байлаа. Рио Тинто, Оюу Толгой хоёр Монгол улсыг хамгийн их дэмждэг олон улсын компани мөн гэдгээрээ би бахархдаг.

Гэхдээ сүүлийн хэдэн чуулга уулзалтын ирц нь арай бага болсон гэж сонссон, энэ нь өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад эдийн засгийн уур амьсгал нь өөрчлөгдсөнийг харуулж байгаа байх.

Харин би үүнийг өөр өнцгөөс харж байна. Энэ хуралд сууж байгаа хүмүүс та бид бүгдээрээ Монголд урт хугацааны тогтвортой байдлыг хүсч буй хүмүүс мөн. Энэ бол жинхэнэ итгэл үнэмшил мөн.

Бид Оюу Толгой төслийг эдийн засгийн үсрэнгүй өсөлтийн үед барьж эхэлсэн юм. Үнэнийг хэлэхэд, энэ өсөлтийг бий болгоход бид өөрсдөө гол үүрэг гүйцэтгэсэн байж магадгүй. Гэхдээ олон сар, олон жил өнгөрөх тусам Улаанбаатар дахь олон улсын хөрөнгө оруулагчдын тоо цөөрсөөр байна.

Энэ нь дотооддоо ч, гадаадад ч тодорхой хэмжээний болгоомжлол төрүүлсэн. Гэхдээ Монгол улс бол орж гараад байх богино хугацааны хөрөнгө оруулалт бишээ. Хэзээ ч ийм байгаагүй.

Оюу Толгойн хөрөнгө оруулагч нар хурдан ашиг олох сэтгэлгээтэй наймаачид биш. Хувь нийлүүлэгчиддээ ашиг шим өгөх нь бидний гол үүрэг хариуцлага мөн боловч манай стратеги нь Монгол дахь үүргийн адил эхнээсээ л урт хугацааны стратеги байсан юм.

Сүүлийн хэдэн сард Оюу Толгойн талаар та бүхэн мэдээллээ зөвхөн хэвлэлээс авч байсан бол Рио Тинто компанийн хувьд Монголд итгэх итгэл үнэмшил нь суларч байна гэж бодож магадгүй.

Үгүй. Шийдвэрлэх асуудал мэдээж бий, гэхдээ Оюу Толгойд байгаа хүн бүрээс та зөвхөн өөдрөг сэтгэл, хүсэл тэмүүллийг л сонсох болно.

Энэхүү өөдрөг сэтгэлийн учир нь гэвэл макро түвшинд юу ч өөрчлөгдөөгүй юм. Манай төсөл бол олон үеийг дамнах маш урт хугацааны төсөл, бидний бодит үнэ цэнийг тухайн нэг цаг үеийн хэмжүүрээр тооцоолох нь буруу.

Рио Тинто бол урт хугацааны, тогтвор сууршилтай ажиллах хөрөнгө оруулагч гэдгээрээ алдаршсан. Бид Монголд бизнесээ эхлүүлэхдээ манай хувь нийлүүлэгчдэд урт хугацааны ашиг шимээ өгөхөөр хөрөнгө оруулж байсан билээ.

Үүний зэрэгцээ бид Монгол улсад оруулсан хөрөнгө оруулалтынхаа эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх өргөн хүрээний ажиллагааг тууштай явуулах болно.

- Бид Монголын бэлтгэн нийлүүлэгч компаниудын сүлжээг бэхжүүлсэний үр дүнд өнөөдөр, үйлдвэрлэлийн эхний жилдээ, манай бэлтгэн нийлүүлэгчдийн гуравны хоёр нь Монгол компаниуд байна.
- Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог шинэчлэх хөтөлбөрөө хэрэгжүүлж Монголын бүх аймагт мэргэжлийн сургалтын хөтөлбөрт залуусыг хамруулж байна.
- Зам, эрчим хүч, усны салбарт бодит дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийж байна.
- ...энэ бүхний дээр, борлуулалтын нэг ч ам.долларын орлого орохоос өмнө бид Монгол улсын төсөвт шууд орлого оруулж одоогийн байдлаар нийт 1 гаруй тэрбум ам.долларын татвар, төлбөр, хураамж төлөөд байна.

2009 онд Оюу Толгой ордыг хөгжүүлэн Монгол улсын хөгжилд хувь нэмрээ оруулахаар байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээ нь бидний түншлэлийн сүүрь үндэс боллоо. Энэ бол нийт оролцогчдод урт хугацааны үнэ цэнэ, ашиг шимийг өгч компанийг эзэмшин ажиллуулах түншлэл мөн.

Энэ гэрээ нь маш чухал байсан хэдий ч, энэ бол түншлэл байгуулах зөвхөн эхний алхам байлаа.

Энэ нь орон нутагт зам, сургууль барих ажлыг эхлүүлэх үндэслэл болсон ч энэ түншлэлийг удаан хугацаанд хөгжүүлж хэрэгжүүлэх юм. Энэ нь уурхай барих шиг хэцүү ажил гэдгийг бид сайтар мэдэж байсан.

Бетон, цемент, ган төмрөөр зам, баяжуулах үйлдвэр зэргийг барьж бий болгодог.

Харин урт хугацааны түншлэл бол итгэл үнэмшил, итгэл найдвар, ойлголцол дээр тогтдог, энэ бүгд сорилт бэрхшээлийг хамтдаа даван туулсанаар бий болдог юм.

Хамгийн бат бөх түншлэл бол саад бэрхшээл, хүнд хэцүү үеийг хамтдаа даван туулснаар бий болдог. Ийм төрлийн түншлэл нэгэнт байгуулсан бол сорилт бэрхшээл нь багасгахгүй ч тэднийг даван туулахад амар болдог юм.

Оюу Толгой бол тавин жил, жаран жил, магадгүй зуун жил ч ажиллах болно. Гурван жилийн бүтээн байгуулалт, өнгөрсөн жилийн туршид гарч ирсэн тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх цаг хугацаа бол Оюу Толгойн урт хугацааны түүхийн өчүүхэн бага хэсэг л байх болно.

Иймд Г.Батсүх даргын өчигдөр хэлснээр бид бүгд Оюу Толгойг ч, Монгол улсыг ч хөрөнгө оруулалт татах чадвараар нь зөвхөн нэг цаг мөчөөр биш, бүхэл бүтэн амьдралын түүхээр нь авч үзэх нь илүү зүйтэй байх.

Оюу Толгой компанийн хөрөнгө оруулагчид болох Туркойз Хилл ба Рио Тинто компаниуд Оюу Толгойн далд уурхайн цаашдын бүтээн байгуулалтын хүрээнд шийдвэрлэх ёстой асуудлуудын талаар Монгол улсын Засгийн газартай хэлэлцээгээ үргэлжлүүлж байна.

Далд уурхай бол Оюу Толгойг маш онцгой компани болгоно. Цаашид энэ нь төслийн нийт өртгийн 80%-ийг эзлэх болно.

Түр зогсоох шийдвэр гартлаа хийсэн бүтээн байгуулалт дээр ажиллаж байсан монгол, гадаадын ажилчид далд уурхайд нийт 15 км урт хонгил барьж, тухай бүртээ 6 метрийн тэсэлгээ, газар шорооны ажлыг гүйцэтгэж байлаа. Тэдний ажил үнэхээр гайхамшигтай бөгөөд бид бүгд тэднийг буцаж ирэх өдрийг тэсэн ядан хүлээж байна.

Олон оролцогч талууд энэ өдрийг хурдан ирээсэй гэж хүсэж байгааг ойлгож байна. Гэхдээ энэ үйл явцыг хурдаар хэмжиж болохгүй. Бид асуудлуудаа **зөв аргаар**, урт удаан хугацаанд хэрэгжихээр шийдвэрлэх ёстой.

Түргэн хурдан аргаар аливаа бизнесийн эсвэл улстөрийн асуудлыг шийдвэрлэж болно гэвэл худлаа амлалт болно. Учир нь манай салбарт богино хугацааны шийдэл нь урт хугацаанд үр дүнгээ өгдөггүй юм.

Энэхүү үргэлжлэн явагдах хэлэлцээгээс гадна сүүлийн үед нэгэн шинэ хэлэлцүүлэг гарч ирснийг ажиглалаа. Эдгээр богино хугацааны асуудлыг шийдвэрлэсний дараа Оюу Толгойн ирээдүйг хэрхэн улстөрийн маргаантай асуудал бус, бизнесийн байгууллагын асуудал болгож хувиргах вэ?

Энэ бол бодмоор л зүйл. Гэхдээ бодит маргаан бол үүнээс нарийн учиртай гэж бодож байна. Оюу Толгой бол зөвхөн бизнесийн байгууллага ч биш; энэ бол урт хугацааны, хөрөнгө их шаардсан, сорилт бэрхшээл ихтэй салбарын уул уурхайн бизнес мөн.

Улстөр бол тогтворгүй байдаг, харин бизнес, ялангуяа уул уурхайн салбар гэдэг нь тасралтгүй тогтвортой байдал шаардсан байнгын ахиц дэвшил, сайжруулалтын үйл явц мөн билээ.

Улстөрийн сорилтууд өөрчлөгдөн шинэ асуудал байнга гарч ирдэг. Засгийн газрын хувьд ойрын хугацаанд тулгамдсан нийгэм, эдийн засгийн асуудалд баригдахгүйгээр олон арван жилийн туршид үр дүнгээ өгөх хөрөнгө оруулалт дээр анхаарч ажиллахын тулд асар их алсын хараа хэрэгтэй юм.

Хөрөнгө оруулагчдын хувьд ч ийм бэрхшээл гардаг. Бид хувь нийлүүлэгчдийн өмнө хүлээсэн үндсэн үүрэг хариуцлагаа хэзээ ч мартажгүй, гэхдээ бидний хувьд үйл ажиллагаагаа явуулж буй орон нутгийн хэрэгцээ ч ийм том төслийн нэгэн салшгүй хэсэг болж байдаг.

Бизнес, Засгийн газарт тулгарах бэрхшээлүүдийг зохицуулах нь маш том сорилт. Гэхдээ энэ сорилтыг шийдэмгий тууштай байж л даван туулах болно.

Эдийн засаг цаашид ч унаж өсөж байх болно. Монголд эдийн засаг дахин огцом өсч болохыг ч үгүйсгэх аргагүй. Гэхдээ богино хугацаанд цаг агаарыг урьдчилан таамаглах нь ач холбогдол багатай.

Монголын уул уурхай бол маш урт хугацаанд ажиллах салбар.

Хөрөнгө оруулалт нь хэдэн долоо хоног, хэдэн сараар биш, харин олон жил, олон арван жилээр үргэлжилдэг юм.

Рио Тинтог хэдэн жилийн өмнө Монголд татаж оруулсан хүчин зүйлс одоо ч өөрчлөгдөөгүй хэвээр байна. Үүнд,

- Бид дэлхийд олон жил илэрч байгаагүй гайхалтай ордыг хөгжүүлсээр байна.

- Бид дэлхийд өөрийнхөө байр суурийг олох замд яваа бахархал бүхий ардчилсан нэгэн оронд ажилласаар байна.
- Монгол улс дэлхийн хамгийн том өсөх зах зээлийн хөрш хэвээр байна. Баруун Австралиас олборлосон ашигт малтмал нь дөнгөж усан боомт хүрэх хугацаанд манай зэсийн баяжмал хэдийнэ БНХАУ-руу очсон байх болно.

Оюу Толгойд гэрэлт ирээдүй бий. Өнөөдрийн энэ агшин бол урт удаан, амжилт бүхий түүхийн нэг хоромоор л үлдэнэ.

Монголд хөрөнгө оруулах хэрэгтэй юу гэж надаас асуувал, та хэр итгэл үнэмшилтэй, хэр их хичээл зүтгэл гарган ажиллаж чадах вэ гэдгийг танаас асуух болно.

Танд ийм итгэл үнэмшил, тууштай үнэнч байх сэтгэл байвал, Монгол Улс дэлхийн аль ч улсаас илүү урт хугацааны хамгийн ашигтай хөрөнгө оруулалт хийх улс мөн хэвээрээ л байна.

Сорилтуудыг даван туулах болно, харин эдгээр тууштай үнэнч хүмүүс Монголын түүхийн нэгэн хэсэг болж үлдэх болно.

ТӨГСГӨЛ